

МОНГОЛ ДАХЬ ТАЙЖ УГСААТАН ЛАМ БОЛОХ ЯВДАЛ НИЙГМИЙН СОНИРХОЛТОЙ ҮЗЭГДЭЛ БОЛОХ НЬ (XVIII-XX ЗУУНЫ ЭХЭН ҮЕ /

Х.Мөнхбаяр

Улс төрийн талаар хэлмэгдэгсдийн Судалгааны төв.

Өгүүллийн товч: Манжийн үеэс 1923 он хүртэлх Монголын нийгмийн дээд давхрааны нэг хэсэг болж байсан дөрвөн зэргийн тайж нараас сахил санваар хүртэж, лам болох нь нэлээд түгээмэл болж байсан. Эл судалгаагаар үүний учир шалтгааныг хурангуйлан авч үзэв.

Түлхүүр үг: "Гэрээс магад гарах тэмдэгт бичиг", давхраа, лам, тайж, "тайжаа байж лам болох", тойн, хохь тайж, "хөвгүүд лам болох".

1921 оны Үндэсний Ардчилсан хувьсгалын өмнөх үеийн монголын нийгэм нь бүтэц, давхраажилтын хувьд ихээхэн сонирхолтой төлөв байдлаар тогтож байсан төдийгүй, мөн үед нийгмийн ялгарал туйлдаа хүрч, дээд, дунд, доод хэмээх үндсэн давхраанууд "төгс" утгаараа бүрэлдэн тогтсон бөгөөд эдгээр нь дотроо бас хэд хэдэн бүлэглэлд хуваагдаж байв. Мөн давхаргууд нь хар, шар буюу иргэний болон шашны гэсэн заагтай байлаа.

"Энгийн" хүмүүсийн нийгмийн давхаргын хамаадал нь ерөнхийдөө "заяагдмал" шинжтэй байсан бол, харин лам нарт эл нөхцөл нь дээрхээс тэс өөр байдалтай, тухайн хувь хүний чадварын цар хүрээнээс хамаарч байжээ. Энэ нь "шар"-ынханы хувьд нийгмийн давхраажилтын орой өөд тэмүүлсэн мобиль хөдөлгөөн өрнөх нөхцөл, өөрөөр хэлбэл нэг давхаргаас нөгөөд дэвшин шилжих боломж байсныг илтгэж байна.

Тиймээс, давхраажилтын орой өөд мацсан хөдөлгөөн өрнөх боломжгүй, тэр ч бүү хэл давхраажилтын суурь руу амархан халтираад, нийгмийн ёроолын хэсэгт гулсан орчих "боломжтой" байсан энгийн ард олны дунд болон доод давхрааны зүгээс "шар" -ын бүлэгт шилжих, өөрөөр хэлбэл сахил хүртэж лам болох явдал түгээмэл тохиолдож байв.

"Манж нар хүн ам олонтой Хятад орныг захирч байхын тул байлдааны чадвартай нүүдэлчин Монголчуудыг зарим талаар өөрийн холбоотон байдалтай байлгаж байх" үүднээс "Манжийн хааны албат ардуудыг байтугай, ноёд тайж нарын хувь харъяат нараас ч олноороо лам болохыг хуулиар цаазлан хориглож, нэг хошуунд 40 ламтай байлгахыг зөвшөөрч" байсан боловч, "XIX зууны үеэс лам болох хүмүүс Гадаад Монголын ТЗЯЯ-наас <<гэрээс гарах тэмдэгт бичиг>> авдаг байсан Манжийн хуулийн заалт хэрэгжихээ больж, хүссэн хүн хошууны ноёноосоо зөвшөөрөл авах төдийхнөөр дураараа шахам лам болох" болсноор, "Манжийн эрхшээлийн сүүл үед уг хязгаар алдагдаж, хошуудын лам нар хэдэн арав зуугаар тоологдох хүртлээ олшир"-ч, "XIX зууны сүүл үе гэхэд Монголын лам нарын тоо нийт эрэгтэйчүүдийн 1/3-ийг эзлэх болсон бөгөөд зөвхөн ар Монголд 100000 гаруй лам байжээ"¹.

"Эрдэмт" лам болох гэсэн энэхүү "аян" нь Манжийн төрийн хүнд алба, ноёд тайж нарын элдэв дарамт шахалтаас зайлсхийж, арай уужуу тайвуу амьдрахыг хичээсэн оролдлого байсан төдийгүй, өөдлөн дэвжих боломжтой бүлэгт шилжин, давхаргын хувьд ахих гэсэн сэдлээс үүтгэлтэй байсан нь тодорхой.

Гэвч, лам нарын бүлэгт шилжих явдал нь зөвхөн дунд доод давхаргынхнаас үүсгэгдэж байгаагүй бөгөөд энгийн хүмүүсийн дээд давхрага болсон язгууртнуудын зүгээс ч лам болох нь цөөнгүй байжээ.

¹ "Монгол улсын түүх. IV боть. УБ., 2003. Т-211-212

Олноо Өргөгдсөн Монгол Улсын Дотоод яаманд Сэцэн хан аймгийн чуулган даргаас өргөсөн нэгэн нугалбарт, тус аймгийн төрөл бус болон төрлийн тайж нарын 61 хөвгүүн лам болж бурхны сурталд орсугай хэмээн гуйсан² тухай өгүүлсэн байдаг. Мөн яамны нэгэн дансанд, чин ван Лхаваанноровоос өөрийн хөвгүүнд гэрээс магад гарахын тэмдэгт бичиг олгуулж, лам болгуулахыг хүссэн явдлыг тэмдэглэсэн³ нь бий.

Түүнчлэн, мөн яамны данснүүдэд, "сайд бээс Түдэнгийн хошууны тайж Тогтохыг лам болгохыг гуйсныг ёсоор болгосон явдлыг зохих газар тушаах бичиг нэгэн зүйл"⁴, "тайж лам Доржпаламын гэвш Чойгоос нэхэж тэмцсэн өрийг шууд хөөн төлүүлэхээр шийтгэж тушаасан зэрэг хэргийн бичгүүд"⁵, "одоо дөрвөн зэргийн тайж нараас лам болсугай хэмээгчдэд хуучин одоогоор тэмдэгт бичиг олгуулж бүхий учир хэлэлцэх газаргүй"⁶, "тайж лам нарт гэрээс магад гарахын тэмдэг олгуулах ба олгогдоогүй тайж нарт уг зэрэг олгуулах явдлыг айлтгаад ..." ⁷ гэхчлэн бичгүүд олонтаа тохиолддог.

Бас, мөн яамны нэгэн дансанд, "Дотоод Хэргийг Бүгд Захиран Шийтгэгч Яамны бичиг. Гэрээс магад гарахын тамга дарсан бичиг олгосны учир; Сэцэн хан аймгийн Хурц гүн Түдэнгийн хошууны дөтүгээр зэрэг тайж Ашид Өлзийцог энэ жил хорин нэгэн хоёр настай. Бурханы суртлыг дагаж дуртай лам болсугай хэмээн гуйсныг ёсоор болгож, манай газраас тайж лам Ашид Өлзийцогт гэрээс магад гарахын тамгатай бичиг нэгэн хувийг олгуулсны тулд, жич гурван үүдний бишрэлээр шар шашны суртлыг дагаж, ариун ёсыг сахиж, амьтны тусыг хичээж явбаас зохимой. Жич: Нэгэнт тэмдэг бичиг авсны хойно зоригоор хар болж үл болмуй. Олноо Өргөгдсөний хоёрдугаар он, арван нэгэн сарын арван хоёрон"⁸ гэжээ.

Дээрх баримтуудыг нягтлан үзвэл, ямар боловч язгууртнуудаас лам болох явдал нь доорх хоёр хэлбэртэй байсан нь мэдэгдэж байна. Үүнд:

- Язгууртнуудын насанд хүрээгүй хөвгүүдээс лам болох буюу 5 настайдаа дацан, хийдэд шавилж, хувраг болдог.
- Тайж нараас хэргэм зэрэг алба тушаалаа "орхиж", санваартан болох буюу аль нэгэн хийдэд сууж, хурлын лам болдог байв.

Эндээс, XX зууны эхэн үеийн Монголын нийгмийн давхраажилтын өвөрмөц үзэгдэл болж байсан, тайж нараас нэгэнт залгамжилсан хэргэм зэрэг алба тушаалаасаа татгалзаж, лам болдог нь чухам ямар учир шалтгаантайг судлаачид урьд өмнө нь төдий л анзаарч байгаагүй бололтой. Энэ нь хэд хэдэн учир шалтгаантай мэт. Энэ нь нэгдүгээрт тухайн хүн өөрийн шийдэл буюу дур сүсгээр, хоёрдугаарт ойр дотныхоо хүмүүсийн саналаар хувраг болдог байсан гэхэд болмоор. Ялангуяа, таван настайгаасаа дацан буюу хийдэд шавилан суралцаж буй хөвгүүдийн хувьд бол тэднийг эцэг эх, дотны хүмүүс нь л хувраг болгохоор шийдвэрлэдэг байжээ.

1918 оны байдлаар, Монголд 205 засаг ба засаг бус ноёд байсан бол, тайж нарын тоо 13274 байсан⁹ бөгөөд ноёдын үе улирах залгамж халаа нөхвөр хүчин болох тайж нарын үнэмлэхүй олонхи нь дөтгөөр зэргийнх, цөөнх нь тэргүүн зэрэгтэй болно¹⁰.

² МУУТА. Ф-А3, Д-1, ХН-124, Х-223-228

³ МУУТА. Ф-А3, Д-1, ХН-15, Х-7

⁴ МУУТА. Ф-А3, Д-1, ХН-124, Х-5

⁵ МУУТА. Ф-А3, Д-1, ХН-40, Х-49

⁶ МУУТА. Ф-А2, Д-1, ХН-164, Х-10

⁷ МУУТА. Ф-А3, Д-1, ХН-15, Х-29

⁸ МУУТА. Ф-А3, Д-1, ХН-16, Х-87

⁹ Майский И.М. Орчин үеийн монгол (Автономит монгол XX зууны гараан дээр). УБ., 2001. Т-41

¹⁰ Гүндсамбуу Х. Монголын нийгмийн давхраажил: Хөгжил, хандлага (XX зуун). УБ., 2002. Т-141

Түүхч Ш.Нацагдоржийн бичсэнээр, 1844 оноос буюу Төр Гэрэлт хааны үед Манжийн төрөөс "гурван аймгийн албан гаргах дүрэм хэмжээ илүү дэлүүгүй харин явуулбал зохих" зүйлийг баталснаар, "Манжийн эхэн үед алба үзэхгүй явсан тайж нар энэ цагаас эхлэн албан ёсоор өөрсдийн хөрөнгө малаар улсын албыг гүйцэтгэх болсон хэрэг...Хэдийгээр тайж нараар үүрд алба гаргуулахгүй, зөвхөн түр хугацаагаар алба гаргуулахыг заасан боловч, тайж нар Манжийн төрийг устан усттал алба гаргасаар иржээ...тайж нар зөвхөн улсын албыг хаах болсон төдийгүй, тэднээс засаг ноёд хувьдаа алба гувчуурлах явдал элбэгшиж ирсэн байна"¹¹.

Ийнхүү бүх тайж нараар улсын чанартай албыг хаалгах журам тогтжээ. Энэ бол тайж нарын нийгэмд илүү эрх дархтай байдаг уламжлалыг халж эхэлсний нотолгоо юм. Энэ үеэс эхлэн тайж нар чухамдаа "харц ардын адил албан гаргах" болсон байна. Манжийн төрийн алба тасалдуулсан тайж нарыг хуулийн заалтаар залхаан цээрлүүлж шийтгэдэг байжээ. Тайж нар улсын албыг хураалгахаас зайлсхийж, "хуучин суртлаар албан гаргуулахгүй болгохыг" шаардан заргалдах явдал олонтоо гарч байв.

Харин, тэр үед бүх санваартан урьдын адил нийгэмд хүндтэй байр суурь эзэлж, төрд ямар нэгэн алба төлддөггүй байсан явдал нийгмийн дээд давхрааны нэг хэсэг болох тайж нар арга буюу лам болж, төрийн албанаас зайлсхийх боломж эрэлхийлэхэд түлхэц болсон байна.

1701 онд Энх-Амгалан хаан: "халхын тайж нарын дотор морьгүй явган явах нь буй. Бие тайж бөгөөд хэрхэн ийм болсон ажээ. Гагцхүү танай монголчууд аж төрөхөд огт бодон төсөөлөхгүйн учир буюу"¹² хэмээж, тайж нарт тусламж үзүүлж байсан удаатай.

Ер нь, XIX зууны эцсээс эхлэн Монголын тайж нар ихээхэн ядуурах болсон төдийгүй "өөр бус чуулганы баялаг хүмүүст өөрсдийн төрсөн үр хүүхэд, авааль эмийг дураар худалдан өгөх, Орос, иргэд, Монголчуудад боол зардас болгон" өгөх явдал ч түгээмэл байв. Тэр ч бүү хэл, ямар ч хамжлагагүй, хөрөнгө чинээгүй "хохь" хэмээх тайж нар олширсон төдийгүй Манжийн үед албан бичиг хараанд <<албаны ядуу тайж ард>> гэдэг нэр томъёо нэгэнт баттай орж, хэрэглэгдэх болсон аж¹³. Ийнхүү амьжиргаагаа залгуулах аргагүй бологсод хийдэд шавилж, өдрийн хоолоо хялбар олж хүртэх арга эрэлхийлэх болсон байна.

Гэсэн ч, тайж нарын ядуурч хоосрох байдал 1911 оноос хойш ч үргэлжилсээр байжээ. Жишээлбэл; 1918 онд дөрвөн аймгийн хүн малыг тоолж, элдэв албыг хуваарилан тогтоохдоо тайж нарын ядуурсан байдлыг харгалзан, тайж нарын хөрөнгө малд хувь тогтоон ам тус бүрт тодорхой тооны мал тайлан олгохоор төлөвлөж байсан боловч, эцэст нь "дөрвөн зэргийн тайж нарт мал тайлах хувь олгуулахыг хэрэгсэхгүй" болгохоор тогтоож байсан.

Энэ бүхэн нь, тайж нар нийтээрээ биш юмаа гэхэд олонхи нь ядуу байжээ гэдгийг илэрхийлж байгаа бөгөөд "тайжаа байж лам болох" явдлын зонхи нь үүнтэй холбоотой байжээ. Өөрөөр хэлбэл, тайж нар санваартан болох нэг үндсэн шалтгаан нь тэдний амьжиргааны ядуурал байна. Тайж нар ядуурч хоосрох болсон нь Манжийн төрийн алба хэт нэмэгдсэн зэрэг зохих шалтгаантай байсан юм.

Ер нь, Манжийн төрийн алба хэт нэмэгдсний улмаас болон бусад шалтгаанаар хувраг болсон зарим тайж буюу засаг ноёдтой холбогдох сурвалж цөөнгүй байдаг нь бидний дээр үгүүлсэн саналыг баталж байна.

Жишээлбэл; Олноо Өргөгдсөн Монгол улсын Дотоод яамны нэгэн дансанд, "...биед тогтсон архаг өвчин бүхий, эм хөвгүүд хамжлага ардгүй

¹¹ Нацагдорж Ш. Халхын түүх. УБ., 1963. Т-147, 148

¹² МУТНС. Монгол Журганаас ирсэн ба явуулсан бичгийн хуулбар

¹³ Нацагдорж Ш. Халхын түүх. УБ., 1963. Т-148

дөтгөөр зэрэг тайж Тогтох дуртай лам болж, бурхны суртлыг дагаж зовлонг залбирсугай хэмээсний тулд үүнд гэрээс магад гарахын тэмдэгт бичиг олгуулахыг гуйсугай"¹⁴ хэмээснээс гадна, Түшээт хан аймгийн Харчин өмнөд засаг улсад туслагч гүн Галсансодномын хошууны засгаас огцруулсан гүн Сандагаас ирүүлсэн бичигт, "...эдүгээ гүн би насан өтөлж 2 нүдний үзэл огт үгүй болсон бөгөөд албан хэрэгт тусгүй болсон учрыг гаргаж огцруулахыг эрж, зохих газраа мэдүүлсэн тухайд ... гуйсан ёсоор болгож, гуравдугаар хөвгүүн Галсансодномд засаг, улсад туслагч гүнгийн хэргэм тушаал хүртээн залгамжлуулж, гүн өчүүхэн намайг засгаас огцруулж, уг зэрэг жинсийг хэвээр хадгалуулж, хишиг хүртээн тушаасан зүйл буй билээ. Эдүгээ болбоос, гүн надад насны доройтол улмаар үлэмждэж бүхий тул, ийнхүү хувраг сахил хүртээвээс болох, үл болохыг зохих газраас лавлаж тогтоолгон заалгамай хэмээн шилжүүлэн ирчүхүй ... Манай Монголчууд шарын шашныг хүндэтгэн эрхэмлэх учир хиа тайж нар лам болж, гэрээс гарахын тэмдэгт бичиг олгуулах хуулийг дагаж, Дотоод яамнаас ёсоор болгож, тэмдэгт бичиг шийтгэн олгосоор буй бөгөөд энэ болбоос гүнгийн хэргэгийг хүлээж явсан хүн тул хараахан тайж нарт адилтгаваас үл болохын дээр, хойч өдөр журамлан дагаж явбаас зохих хэрэг тул шавь боолчуудын төдий тогтоож үл чадах бөгөөд зарлигаар заан тогтоохыг хүлээвээс зохих тулд ... хичээнгүйлэн айлтгав. Олноо Өргөгдсөний 5-р он, зуны тэргүүн сар..."¹⁵ гэжээ.

Мөн, Сайн Ноён хан аймгийн хошууч мэргэн бэйс Ядамжавын хошууны урьд тушаалын засгаас буулгасан сул бэйс Дугаржавын бичигт, "Дугаржав миний биед язгуураас хуучин оршсон эмгэг өвчин буйн дээр, одоо насан буурай болсон бөгөөд шарын шашинтай зууралдан төрсөн завшаанд мунхаг сэтгэлийг шулуутгаж, доорд биеийг ариутгаж лам болж, шарын сурталд ерөөл тавьсугай хэмээхийг үнэн санаанаас хүсэхийн тул зохих газар лавлан мэдүүлж, лам болгон өршөөлгөж хүссэн сэтгэлийг гүйцэтгэхийг гуйсугай...мөнөөхөн Түшээт хан аймгийн харчин гүн Сандагт санваарь хүртээх явдлыг уламжлан гуйн айлтгаад зарлиг ёсоор болгосныг хичээнгүйлэн дагаж шийтгүүлсэн хэрэгт даруй нийлэлцэхийн тулд, энэхүү сул бэйс Дугаржав түүний гуйсан ёсоор явуулбаас болох ба үл болох явдлыг ...айлтгаад гуйх нь ..." ¹⁶ гэсэн байна.

Эдгээр баримтуудыг нягтлан үзвээс, бие доройтож, насан өтөл болохын үед үүсвэрлэсэн, нүглээ наманчилж, биеэ ариутган диваажинд очих хүсэл нь тайж нарын лам болох нэгэн сэдэл болж байжээ. Түүнчлэн, тайж нарын лам болох явдал нь Олноо Өргөгдсөн Монгол Улсын үед улам дэлгэрч, тэр байтугай Монголын түүхэнд анх удаа гүн, бэйс хэргэмтэй ноёдоос хэргэмээ орхиж, лам болох явдал гарч байв.

1911 онд Олноо Өргөгдсөн Монгол Улс байгуулагдаж, хааны сэнтийд Монголын шарын шашны тэргүүн VIII Богд Жавзандамба хутагт заларч, улсын бүх эрх түүнд төвлөрснөөр, тухайн үед нийгмийн зүгээс шарын шашин түүний зүтгэлтнүүдэд хандах үнэлэмж эрс өндөрсч, лам нарын зүгээс төрийн хэрэгт оролцох нь их болсон байна.

Жишээлбэл; Шинэ байгуулагдсан Монгол улсын засгийн газрын Дотоод яамны сайдаар да лам Цэрэнчимэд (1912 он), дараа нь (1914 он) уг тушаалд да лам Дашжав, Шашин төрд туслах яамны сайдаар Шанзудба Бадамдорж, 1915 онд Сангийн яамны сайдаар Их шавийн хийдчин отгийн нэртэй баян бөгөөд нийслэл хүрээний нөлөөтэй лам Лувсанбалдан, Гадаад яамны дэд сайдаар да лам Равдан, Шүүх яамны дэд сайдын тушаалд да лам Цэрэндондов, Дотоод

¹⁴ МУУТА. Ф-А3, Д-1, ХН-124, Х-71

¹⁵ МУУТА. Ф-А3, Д-1, ХН-658, Х-46

¹⁶ МУУТА. Ф-А3, Д-1, ХН-659, Х-3

яамны дэд сайдаар да лам Пунцагдорж нарын зэрэг ихэс лам нар тус тус удаа дараалан томилогдон ажиллаж байжээ.

Түүнчлэн, Богд хаанаас эхэн үедээ ихэс лам нарт хар ноёдын хэргэмүүдэд дүйцэх цалин пүнлүүг олгож байсан¹⁷ боловч, яваандаа хар ноёдын хэргэм зэрэг цолыг лам нарт өгч эхэлсэн бөгөөд улмаар, энэ байдал нь хэргэм зэргийг төрөөс "худалдах" хэмжээнд хүртлээ хавтгайрч, томоохон лам нарын хэргэм зэрэг, цол, эрх яамбын хувьд хар ноёдоос дутах нь бүү хэл давах хэмжээнд хүрчээ. Тухайлбал; сурвалжуудад шадар сайд, гурван зэрэг нэмсэн, хоёр зэрэг тэмдэглэсэн, нягт билэгт, хурц сэргэлэн, хичээнгүй нансу, жүн ван, да лам Пунцаг, тэргүүн сайд Эрдэнэдалай Шанзудба дөрвөн зэрэг нэмсэн, нэг зэрэг тэмдэглэсэн, билэгт нансу, хичээнгүй нягт, үнэн зоригт жүн ван лам Дашжав, чин сүжигт чин ван лам Цэрэнчимэд гэх мэтчилэн дурьдагддаг.

Энэ бүхэн нь, Монголын нийгэм дэх лам нарын нэр хүнд байр суурийг маш их өргөсөн төдийгүй, төрийн дэмжлэг болон түүхэн зайлшгүй "оноолт"-ын дүнд лам нар улс орны хувь заяаны төлөөх тэмцэлд зарим талаараа манлайлах үүрэг гүйцэтгэх болжээ.

Жишээ нь, Жалханз хутагт Дамдинбазар, Егүзэр хутагт Галсандаш нар баруун болон зүүн хязгаарын олон Монгол аймгийг дагуулан тохинуулж захирч байхад, 1915 оны гурван улсын хэлэлцээрт Монголын төлөөлөгчдийг дотоод яамны тэргүүн сайд, улсад туслагч гүн, да лам Дашжав нар тэргүүлэн оролцож улс орныхоо тусгаар тогтнолын төлөө тууштай тэмцэж байв.

Тэрчлэн, Ялгуусан баатар, улсад туслагч, гүн да лам Галсанцэвэгтүгням, Жиримийн чуулганы Өлзийт хамба, Үйл бүтээгч гэгээн Даваа-Аюушпэрлээнэмжил зэрэг лам нар цэрэг ардыг шаламгайлан удирдаж, Хятадын хар цэрэгтэй баатарлагаар тулалдаж явсан удаатай.

Мөн үед мяндаг тушаалтай лам нар болон ноёдыг нэгэн зиндаанд авч үзэх хандлага нилээд өргөжиж ирсэн байна. Тухайлбал, Олноо Өргөгдсөний 2-р онд Дотоод яамнаас зэрэг дэвийг үзэж, зөвлөн тогтоосон, Нийслэл хүрээнд буух зочдод хүнс буулгахдаа дагах журамд заасан нэгэн өдөрт олгох хүнс мөнгөний жагсаалтыг хүснэгтэнд буулган үзвэл:

№	"Хар" ноёдын		"Шар" ноёдын	
	Хэргэм, зэрэг	1 өдрийн "Хүнс" мөнгө	Хэргэм, зэрэг	1 өдрийн "Хүнс" мөнгө
	Хан	7 лан	Улсын багш Самади багш	7 лан
	Чин ван	6 лан	Хутагт	6 лан
	Жүн ван	5 лан	Номун хан ба Хамба	5 лан
	Бэйл	4 лан 5 цэн		
	Бэйс	4 лан	Цорж	4 лан
	Түшээ гүн	3 лан 5 пүн		
	Туслагч гүн, барга Дарьгангын бүгдийн дарга нар	3 лан	Хувилгаан	3 лан
	Засаг тайж ба барга Дарьгангын дэд дарга, гарын дарга, тэмдэгт сумын занги	2 лан	Засаг лам, да лам	2 лан
	Тэргүүн зэргийн түшмэд	1 лан 5 цэн		
	Гутгаар, дөтгөөр зэргийн түшмэд	1 лан	Дэмч, зайсан	1 лан
	Тав, зургадугаар зэрэг түшмэд	8 цэн	Зайсангаас дорогш, хаалгачаас дээш тушаалын лам нар	8 цэн
	Дагах ардууд	5 цэн	Дагагсад	5 цэн

¹⁷ Урангуа Ж. Хэргэм, зэрэг, цол, өргөмжлөхүй (XVII-XX зууны эхэн). УБ., 2000, Т-105

дээрх байдалтай байна.¹⁸

Олноо Өргөгдсөний 9-р онд, Ёслолын хэргийг хавсарсан Дотоод яамны, "Дээдийн амгаланг айлтгах хамба хутагт, хувилгаан сайд, хаад, ван, гүн, засаг, тайж нарын зэрэг дараалал" бичсэн дансан дахь мэдээг нягталвал:

	"Сайн уу?" хэмээн дээд зэргээр мэндлүүлэгсэд		"Мэнд үү?" хэмээн удаах зэргээр мэндлүүлэгсэд	
	Төрийн ордонд биеэр амгаланг айлтгасан	Төлөө хүнээр амгаланг айлтгасан	Зүүн ордонд биеэр амгаланг айлтгасан	Төлөө хүнээр амгаланг айлтгасан
Ихэс лам нар	17	28	5	35
Ноёд	5	15	42	131
Бүгд	22	43	47	166

ийм байгаа¹⁹ бөгөөд тэргүүн зэргээр хүндлүүлж, "Сайн уу?" хэмээн мэндлүүлэх 65 хүний 45 нь "шар" ноёд, 20 нь "хар" ноёд байхад, харин дэд зэргээр хүндлүүлж, "Мэнд үү?" гэж мэндлүүлэх 213 хүний 173 хүн нь "хар" хүн, 40 нь "шар" хүн байгаа нь сонирхолтой.

Дээрх баримтууд нь Олноо Өргөгдсөн Монгол улсын хувьд ихэс лам нар хар ноёдыг бодвол харьцангуй өндөр байр суурь эзлэх болсныг илтгэж байна. Тэр ч бүү хэл Шашин Төрд туслах Сайдын Газраас 1913 онд Сэцэн хан аймгийн чин ван Гомбосүрэнг Их Хүрээний хамба Номун хан ламыг доромжилсон шинжтэй үг хэлсэн хэмээн чуулган дарга бөгөөд Дотоод яамны дэд сайдын тушаалаас нь огцруулжээ. Энэ тухай зарлигт "...Дотоод яамны дэд сайд, хан Хэнтий уулын чуулганы дарга чин ван Гомбосүрэн нь хамба номун хан Пунцагийг даншиг өргөх ёслол үйлдэж байх үед өргөх мөнгөө даахгүй ядаж байна уу хэмээв, зарлиг, ван Гомбосүрэнг тушаалаас болиулагтун" гэжээ. Энэ мэтээр шар ноёд нь хар ноёдыг улс төрийн талаар эрс давамгайлан захирах болжээ.²⁰

Тухайн үед төрийн бодлогын дүнд шарын шашны байгууллагууд ихээхэн бэхжиж байжээ. Олноо Өргөгдсөний 4-р онд Богд хаанаас Бүгд Ерөнхийлөн Захирах сайд, Сайн Ноён хан Т.Намнансүрэнд буулгасан зарлигт, "Манай монголчууд эртнээс нааш ямагт шарын шашныг эрхэмлэж, өрнүүлэн дэлгэрүүлсээр ирсний тулд, үүнээс урагш Нийслэл Хүрээний Хамба Номун Хан, дэд Хамба нарыг тэргүүн сайдуудаас ахлуулж, бас Шашин Төрд Туслах сайд, Эрдэнэ Шанзодба-г Бүгд Ерөнхийлөн Захирах зэрэг 6 яамны тэргүүн сайдуудын дараагаар жагсааж, аливаа хурал номын ба албаны газар ёслох, жагсаах, хурах, суух зэрэгт цөм энэ ёсоор дагаж явуулагтун хэмээсэн"²¹-ий сацуу, Олноо Өргөгдсөний 3-р онд Шүүх яамны тэргүүн сайд, Эрдэнэ ван На-д буулгасан зарлигт "Үүнээс урагш Нийслэл хүрээнээ сууж дацан аймагт захирагдан хурал сургууль үйлдэж бүхий аливаа мяндагтан ба гэлэн гэцэл, санваартай буюу гэнэн боловч хурал сургуулийн ба албан хаах лам хүнийг хэргийн учир зарлан байцаах болбоос Нийслэл хүрээний Эрдэнэ Шанзудбийн яаманд мэдэгдэж, зарлуулах ба хэрэв мяндагтан санваартанд шүүх хэрэг тохиолдвоос урьдаар мөнхүү яамнаа мэдэгдэж, улмаар хамба номун ханд сонсгосон хойно гүйцэтгэн шийтгүүлтүгэй. Түүгээр шууд дайчилбаас болохгүй"²² гэсэн нь нэг талаараа нийт лам нарыг төрийн зүгээс онцгойлон, хамгаалалтанд авсныг илтгэсэн төдийгүй, нөгөө талаараа лам нарын монголын нийгэм дэх байр суурийг тодотгосон явдал болсон.

¹⁸ МУУТА. Ф-А3, Д-1, ХН-14, Х-264-265

¹⁹ МУУТА. Ф-А3, Д-1, ХН-242, Х-2-29

²⁰ Пүрэвжав С. Монгол дахь шарын шашны хураангуй түүх. УБ., 1978. Т-149

²¹ МУУТА. Ф-А9, Д-1, ХН-57, Х-2

²² Жинхэнэ дагаж явах хууль дүрэм (1913-1918). УБ., 2004. Т-63

Ийнхүү, шарын шашин лам нарын нэр хүнд, нөлөө, улс төрийн байр суурь есч, зарим талаараа хар ноёдоос илүүтэй болсон нь олны зүгээс шарын шашныг ихэд анхааран сонирхоход хүргэсний сацуу, тайж нараас гадна ноёдоос “хэргэмээ гээж” лам болоход нөлөөлсөн байж болох юм.

Өөрөөр хэлбэл, Олноо Өргөгдсөн Монгол Улсын хувьд нийгмийн оюун санаа болон улс төр, шашны амьдрал дахь лам нарын ноёлох байдалд дулдуйдан, тайж нараас лам болох явдал түгээмэл болж ирсэн бололтой бөгөөд энэ нь ч эх сурвалжуудаас ажиглагддаг.

Эцэст нь дүгнэхэд, “тайжаа байж лам болох” үзэгдэл нь Манжийн ноёрхлын сүүл үед татвар гувчуур, хүнд албан үүрэг, ядуурал зэрэг эдийн засгийн хүчин зүйлсээс шалтгаалцаж, зөвхөн тайж нарын хүрээнд оршиж байсан бол, харин Олноо Өргөгдсөн Монгол улсын үед гүн, бэйс зэрэг хэргэмт ноёдыг хамарч өргөжих болсон бөгөөд үүний үндэс нь ерөнхийдөө тухайн үеийн Монголын нийгэм, улс төрийн тавцанд лам нарын үүрэг, нэр нөлөө, байр суурь өссөнтэй холбоотой гэж хэлж болохоор байна.

Гэхдээ, VIII Богд Жавзандамба хутагт төрийн тэргүүн болсноос үүдэн, олон түмний сүсэг бишрэл өссөнтэй холбоотойгоор тайж, язгууртнуудаас өөрийн чин сүсгээр сахил хүртэж, хувраг болох явдал байсныг ч үгүйсгэж болохгүй юм.

Ер нь, цаашдын судалгаанд <<тайжаа байж лам бологсод>> буюу тойн лам нар тухайн үеийн лам нарын давхраанд чухам ямар байр суурь эзэлж, хэр хэмжээний үүрэг гүйцэтгэж байсныг судлан тодруулууштай байна.

Abstract: It was a very common practice to take a full ordination as a monk among the noble people those belonged to the four classes of “taij”, which was a part of the upper class of Mongolian society during the long period of time starting from Manchu regime to 1923. The main aim of this research report is to deal with and clarify the reasons those were behind this suprising social phenomena on the basis of archieve materials. At the results of tracing through the different forms of archieve, materials we had drawn following conclusions:

1. Many noble people had rejected their titles and taken vows as the fully ordained monks due to some economical reasons or grounds such as a poverty of the entire society for being under rule of Manchus.

2. When Mongolians had got the independence and formed a theocratic government of “Mahasamatha” Bogd Khaan, the role of Monks was tremendously uplifted in the political and social activities as a whole due to this new structure. That’s why many noble people, even some, who held the highest titles such as “chin van”, “jun van”, “gun”, “beis”, were transforming into the ordained ones.

Ном зүй

1. Болдбаатар Ж. “Да лам; 1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсгалын удирдагчдийн нэг Г.Цэрэнчимэдийн амьдрал үйл ажиллагааны тухай”. УБ., 1997.
2. Жамсран Л. Монголчуудын сэргэн мандалтын эхэн. (1911-1913). УБ., 1992.
3. Гүндсамбуу Х. Монголын нийгмийн давхраажил: Хөгжил, хандлага. (XX зуун). УБ., 2002.
4. Жинхэнэ дагаж явах хууль дүрэм (1913-1918). УБ., 2004.
5. Идшинноров С. XIX-XX зууны зааг дахь монголын нийгэм эдийн засгийн байдлын зарим асуудал. УБ., 1986
6. Майский И.М. Орчин үеийн монгол /Автономит монгол XX зууны гараан дээр/. УБ., 2001.
7. Монголын түүхийн бага нэвтэрхий толь. боть III. УБ., 2002.
8. Монгол улсын түүх. боть IV. УБ., 2003.

9. Монгол улсын түүх. боть V. УБ., 2003.
10. МУУТА. Ф-А3, Д-1, ХН-14
11. МУУТА, Ф-А3, Д-1, ХН-15
12. МУУТА, Ф-А3, Д-1, ХН-16
13. МУУТА. Ф-А3, Д-1, ХН-40
14. МУУТА. Ф-А3, Д-1, ХН-124
15. МУУТА. Ф-А2, Д-1, ХН-164
16. МУУТА. Ф-А3, Д-1, ХН-242
17. МУУТА. Ф-А3, Д-1, ХН-658
18. МУУТА. Ф-А3, Д-1, ХН-659
19. МУУТА. Ф-А9, Д-1, ХН-57
20. МУТНС. Монгол Журганаас ирсэн ба явуулсан бичгийн хуулбар
21. Нацагдорж Ш. Халхын түүх. УБ., 1963. Т-147, 148
22. Пүрэвжав С. Монгол дахь шарын шашны хураангуй түүх. УБ., 1978.
23. Урангуа Ж. Хэргэм, зэрэг, цол,
24. өргөмжлөхүй (XVII-XX зууны эхэн). УБ., 2000.